



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/555

Ховд


Санхүүжилт хангах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 10/06 дугаар тогтоолын 15 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймагт улсын төсвөөс олгох 2020 оны батлагдсан орлогын шилжүүлгийн хувиараас дутуу хийгдэж буй санхүүжилтийг түр нөхөх, 2020 оны орон нутгийн хөгжлийн санд батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлэн аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын санхүүжилтийг олгон үйл ажиллагааг дэмжихээр аймгийн хөрөнгө оруулалтын захирагчийн техник хяналтын дансанд төвлөрсөн орлогын үлдэгдлээс хавсралтад заасан хөрөнгө оруулалт, арга хэмжээнд 185100.0 мянган төгрөг /нэг зуун наян таван сая нэг зуун мянган/-ийг буцаан тооцож төвлөрүүлэх нөхцөлтэйгээр зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

2. Буцаан тооцох нөхцөлтэй зарцуулах 185100.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс тооцож буцаан төвлөрүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 02502

Аймгийн Засаг даргын 2020 оны
09 дүгээр сарын 28-ны өдрийн
А/555 дугаар захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
ГҮЦЭТГЭСЭН АЖЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ЖАГСААЛТ

дд	Хөрөнгө оруулалтыг гүйцэтгэж буй гэрээлэгчийн нэр	Батлагд- сан дугаар	Гэрээний дугаар	Үнийн дүн /мян.төг/
1	Жишиг гудамж /Жаргалант сум Наран баг/	4.31	ХОАОНӨГ202001040	15000.0
2	Сумын төвийн гэр хороололд хүүхэд залуучуудын амралтын талбай байгуулах /Чандмань сум/	2.9	ХОАОНӨГ202001148	16300.0
3	Жаргалант сумын Бичигт, Тахилт, Наран, Рашаант, Алагтолгой, Буянт, Бугат багуудын нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалт	1.2	ХОАОНӨГ201912064/01	14000.0
4	Цэцэрлэгийн их засвар, гудамжны гэрэлтүүлэг, тохижилт /Мөнххайрхан сум/	4.25	ТШ-2020-Ажил-03	16000.0
5	Музейн барилгын засвар, гадна, дотор тохижилт /Жаргалант сум/	4.2	ХОАОНӨГ202001117	10000.0
6	Шинэ халуун ус, үйлчилгээний төв байгуулах /Жаргалант сум/	1.5	ХОАОНӨГ201912054	25000.0
7	Соёлын төвийн барилгын засвар /Чандмань сум/	4.12	ХОАОНӨГ202001073	12000.0
8	ЭМТ-ийн барилгын засвар /Дуут сум/	2.6	ХОАОНӨГ202001142	15000.0
9	ЕБ-ийн 6-р сургуулийн гаднах, хашаа, хайс, биеийн тамирын талбайн тохижилтын ажил /Жаргалант сум, Буянт баг/	4.30	ХОАОНӨГ202001042	10000.0
10	Бургасан багийн айл өрхийг эрчим хүчинд холбох /Зэрэг сум/	2.16	ХОАОНӨГ202001159	10000.0
11	ЕБС-ийн 2 дугаар сургуулийн урлагийн заалны тоног төхөөрөмж /Жаргалант сум/	3.6	ХОАОНӨГ202001121	8000.0
12	Багийн төв барих /Мянгад сум, Чацарганат баг/	2.02	ХОАОНӨГ202001148	10000.0
13	"Малын эрүүл мэнд" хөтөлбөр	5.1	ХОАОНӨГ2020/554	23750.0
	Дүн			185100.0

-оОо-